



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 229

Улаанбаатар хот


Ажлын хэсэг байгуулах
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. “ХДХВ/ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үндэсний стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг үнэлэх ажлын удирдамжийг нэгдүгээр, ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Г.Ганчимэг/-д үүрэг болгосугай.

САЙД



Г.ШИЙЛЭГДАМБА

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 06 сарын 08 өдрийн
229 дугаар тушаалын 1 дүгээр
хавсралт

АЖЛЫН УДИРДАМЖ

Зорилго:

2010-2015 онд хэрэгжүүлэх “ХДХВ/ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үндэсний стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үр дүн, үр нөлөө, ололттой тал, тулгамдаж буй бэрхшээлийг тодорхойлж, стратеги төлөвлөгөөг шинэчлэн боловсруулахад тулгуур болохуйц зөвлөмж боловсруулахад оршино.

Үнэлгээний хамрах хүрээ:

- ХДХВ/ДОХ, БЗДХ-ын урьдчилан сэргийлэлт
- ХДХВ/ДОХ, БЗДХ-ын тусламж, үйлчилгээ
- Лабораторийн оношлогоо
- Удирдлага, зохион байгуулалт, зохицуулалт, нөөц дайчлал болон олон талт хамтын ажиллагаа
- Хяналт-шинжилгээ, үнэлгээ, тандалт судалгаа

Үйл ажиллагааны чиглэл:

- Стратеги төлөвлөгөөний 7 зорилтын хүрээнд дээрх 5 чиглэлээр үнэлгээний багтай байна.
- Багийн ахлагч нь мэдээлэл цуглуулах аргачлалыг боловсруулж, гишүүдийн үүргийг тодорхойлж хариуцсан чиглэл тус бүрээр үнэлгээний үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- Үнэлгээний багийн ахлагч нараас сонгогдсон ахлагч нь багуудын үйл ажиллагааг уялдуулж, хяналт тавьж ажиллана.
- Үнэлгээний хүрээнд баримтын судалгаа хийх, холбогдох хүмүүстэй уулзалт, ярилцлага хийх, холбогдох байгууллагын үйл ажиллагаатай танилцах, орон нутагт томилолтоор ажиллах, үнэлгээний тайланг танилцуулах уулзалт зохион байгуулах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Ололт амжилт, давуу болон сул тал, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, цаашид шийдвэрлэх арга хэмжээ, хэрэгжүүлэх арга замыг тусгасан тодорхой зөвлөмжүүд дэвшүүлнэ.
- “ХДХВ/ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үндэсний стратеги төлөвлөгөө”-ний дунд хугацааны үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг дүгнэнэ.
- Олон улс болон бус нутгийн түвшинд үр дүнтэй нь нотлогдсон, шинэлэг арга хэмжээний талаар судална.
- Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь үндэсний стратегийн тулгуур зарчмуудад тулгуурласан эсэхийг харгалзан үзнэ.
- Стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулсан санхүүжилт, үр дүнг тооцно.
- Стратегийн хэрэгжилтэд үндэсний хэмжээнд болон нийслэл, дүүрэг, аймаг, сумын түвшнээр үнэлэлт дүгнэлт өгнө.


- Шалгуур үзүүлэлтийн биелэлт, хүрсэн түвшинг тооцон шалтгаан, үр дүнд дүгнэлт хийнэ.
- Үнэлгээний тайланг эцэслэн ЭМСЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

Хугацаа:

2015 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 30-ны өдөр

Хүрэх үр дүн:

- “ХДХВ/ДОХ, БЗДХ-аас сэргийлэх үндэсний стратеги төлөвлөгөө”-ний хэрэгжилт, үр дүн, үр нөлөөг тодорхойлж, тулгамдаж буй бэрхшээл, шийдвэрлэх арга замыг тодорхойлж зөвлөмж дэвшүүлсэн байна.
- Үнэлгээний дүнг Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн байна.



Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 06 сарын 09 өдрийн
229 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

1. ХДХВ/ДОХ, БЗДХ-ын урьдчилан сэргийлэлт

Ахлагч: Б.Ариунсанаа, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн /АШУҮИС/ Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн багш

Гишүүд: Б.Сувд, Нийгмийн эрүүлмэндийн хүрээлэнгийн Эрүүл мэндийг дэмжих, зан үйл судлалын секторын эрдэм шинжилгээний ажилтан

Э.Эрдэнэтунгалаг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн /ХӨСҮТ/ ДОХ/БЗДХ-ын Тандалт судалгаан албаны тархвар судлаач эмч

П.Түмэндэмбэрэл, ХӨСҮТ-ийн ДОХ/БЗДХ-ын ТСА-ны нийгмийн ажилтан

С.Хандмаа, АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Зан үйл, нийтийн эрүүл мэндийн тэнхимийн багш

Б.Гансүх, ЭМСЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ,Сүрьеэгийн төслийн ДОХ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн

Д.Мягмардорж, “Залуус-эрүүл мэнд” ТББ-ын Гүйцэтгэх захирал

Х.Ням-Өлзий, “Төгс бүсгүйчүүд” ТББ-ын Гүйцэтгэх захирал

А.Илиза, Монгол Улс дахь НҮБ-ын Хүн амын сангийн хөтөлбөрийн ажилтан (тохиролцсоноор)

2. ХДХВ/ДОХ, БЗДХ-ын тусламж, үйлчилгээ

Ахлагч: В.Наранцэцэг, АШУҮИС-ийн Халдварт өвчин судлалын тэнхимийн ахлах багш

Гишүүд: Н.Эрдэнэбаяр, Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн захирал

Б.Пунцаг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ТСА-ны дарга

Б.Оюунбилэг, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДОХ/БЗДХ-ын Тандалт судалгааны албаны ХДХВ/ДОХ-ын тусламж, үйлчилгээний тасгийн эрхлэгч

Ч.Алтантогосхон, Нийслэлийн эрүүл мэндийн газрын сүрьеэ, ХДХВ/ДОХ, БЗДХ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн
Д.Хишигтогтох, АШУҮИС-ийн Нийгмийн эрүүл мэндийн сургуулийн Зан үйл, нийтийн эрүүл мэндийн тэнхимийн эрхлэгч

Ц.Содномпил, ДОХ-оос сэргийлэх Монголын бизнесийн зөвлөлийн тэргүүн

Д.Болорчимэг, Монгол Улс дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн Өсвөр үе болон ХДХВ/ДОХ-ын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн (тохиролцсоноор)

3. Лабораторийн оношлогоо

Ахлагч: Б.Дармаа, ЭМСЯ-ны Биоаюулгүй ажиллагаа, лабораторийн оношзүйн ерөнхий мэргэжилтэн

Гишүүд: Г.Сарангуа, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Нэгдсэн лабораторийн Албаны дарга

Ш.Мягмарсүрэн, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ХДХВ/ДОХ/БЗДХ-ын Лабораторийн тасгийн дарга

Ч.Баттогтох, АШУҮИС-ийн Биологийн тэнхимийн багш

Л.Энхсайхан, АШУҮИС-ийн Бичил амь, дархлаа судлалын тэнхимийн багш

С.Лхамсүрэн, ЭМСЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ,Сүрьеэгийн төслийн ханган нийлүүлэлт хариуцсан мэргэжилтэн

Ж.Нарантуяа, Монгол Улс дахь ДЭМБ-ын Суурин төлөөлөгчийн газрын хөтөлбөрийн ажилтан (тохиролцсоноор)

4. Удирдлага, зохион байгуулалт, зохицуулалт, нөөц дайчлал болон олон талт хамтын ажиллагаа

Ахлагч: Д.Золзаяа, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын зөвлөх (тохиролцсоноор)

Гишүүд: П. Оюунцэцэг, Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга

Г.Туул, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

Х.Өлзий-Орших, Санхүү, эдийн засгийн хэлтсийн мэргэжилтэн

Ж.Даваалхам, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ДОХ/БЗДХ-ын тандалт судалгааны албаны дарга

Ч.Бямбаа, ЭМСЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн төслийн ДОХ-ын асуудал хариуцсан мэргэжилтэн

А.Нямдорж, Залуучуудын эрүүл мэндийн “Youth LEAD” олон улсын байгууллагын зөвлөх

А.Батбаяр, Монголын Хөгжлийн судалгааны хүрээлэнгийн тэргүүн

Г.Нямпүрэв, “Дэмжих төв” ТББ-ын Гүйцэтгэх захирал

Б.Мягмардорж, Зам тээврийн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын ахлах мэргэжилтэн (тохиролцсоноор)

Ц.Нугармаа, Хууль зүйн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн (тохиролцсоноор)

Л.Жамсранжав, Уул уурхайн яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн (тохиролцсоноор)

Д.Алтанцэцэг, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн (тохиролцсоноор)

Д.Алтанчимэг НҮБ-ын ДОХ-ын нэгдсэн хөтөлбөрийн зохицуулагч (тохиролцсоноор)

5. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, тандалт судалгаа

Ахлагч: С.Ариунтуяа, Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Нийгмийн эрүүл мэндийн тандалт, мэдээллийн албаны дарга

Гишүүд: С.Амарзаяа, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын мэргэжилтэн

Х.Нарантуяа, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн Судалгаа, төлөвлөлт, статистик мэдээллийн албаны мэргэжилтэн

С.Цэгмэд, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн
ДОХ/БЗДХ-ын ТСА-ны статистикч их эмч

М.Сэргэлэн, ЭМСЯ, Глобаль сангийн дэмжлэгтэй ДОХ, Сүрьеэгийн
төслийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Ш.Галбадрах, "Монголын гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг"-ийн
Боловсрол, сургалтын албаны менежер

Г.Эрдэнэтуяа, "Хамтдаа төв" ТББ-ын Гүйцэтгэх захирал

